



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 1/39

Арвайхээр

Аймгийн гамшигаас хамгаалах бэлэн байдлын
Үзлэгийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 б, 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8 дахь заалт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны A/315 дугаар тушаалаар батлагдсан -“Гамшигаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэг зохион байгуулах, үнэлэх журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшигаас хамгаалах “Бэлэн байдлын үзлэг”-ийн бэлтгэл ажлыг хангуулах “Ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, гамшигаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн бэлэн байдлыг хангах, гамшигаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажлыг хариуцан ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Гамшигаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн бэлтгэл ажлыг хангуулах нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, шаардлагатай зардлын төсвийн тооцоог гаргах, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны A/315 дугаар тушаалаар батлагдсан “Гамшигаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэг зохион байгуулах, үнэлэх журам”-ын дагуу бэлтгэл ажлыг чанартай зохион байгуулж, оролцохыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Гамшигаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэгт аймаг, сумдын Онцгой комиссын гишүүд, гамшигаас хамгаалах алба, ерөнхий болон тусгай зориулалтын мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, хуулийн этгээдийн мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүнийг бүрэн хамруулж, мэдээ мэдээллээр ханган ажиллахыг Онцгой байдлын газар, гамшигаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн анги, аж ахуйн нэгж байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4. Аймаг, Сумдын, гамшигаас хамгаалах алба мэргэжлийн ангид аймгийн Засаг даргын нэрэмжит гамшигаас хамгаалах “Бэлэн байдлын үзлэг” зохион байгуулах удирдамж, төлөвлөгөө боловсруулан шалган зааварчлах ажлыг 2019 оны 4 дугаар сарын 10-аас 5 дугаар сарын 10-ны дотор зохион байгуулж, нэгдсэн дүнг 2019 оны 5 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг Онцгой байдлын газрын дарга дэд хурандаа (Д.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД 011100089

Аймгийн Засаг даргын 2019... оны 01.
дугаар сарын 24..ны өдрийн 11.39 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

**АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ГАМШГААС ХАМГААЛАХ
БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ
ХАНГАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч - И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

- Гишүүд:
- Д.Эрдэнэбат (Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа)
 - Ц.Ганболд (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)
 - Д.Нэмэхбаяр (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,
төрийн сангийн хэлтсийн дарга)
 - А.Отгонцэцэг (аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн
хэлтсийн дарга)
 - Г.Баясгалан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө
оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)
 - М.Дэлгэрсайхан (Цэргийн штабын дарга, дэд хурандаа)
 - О.Пүрэвдорж (Арвайхээр сумын Засаг дарга бөгөөд хотын
захирагч)
 - Д.Шиваанурдэв (аймгийн Засаг даргын Эрүүл мэндийн газрын
дарга)
 - Ч.Гүнсэнхорол (Газрын харилцаа барилга хот байгуулалтын
газрын дарга)

Нарийн бичгийн дарга - Н.Намхайнямбуу (Онцгой байдлын газрын Гамшгаас
хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах
мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын
байцаагч, ахмад)

-оОо-

13	Ч.Гүнсэнхорол	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга	а/д Б.Балжинням	Барилга, хот байгуулалтын алба, нүүлгэн шилжүүлэлт, тур байрны мэргэжлийн анги
14	Д.Балданням Д.Лхам-Оролмаа	Тээвэр авто замын газрын дарга, АЗЗА захирал	а/д Д.Бямбатогтох	Зам тээврийн алба
15	Б.Оюунчимэг	Ус цаг уур орчны шинжилгээний албаны дарга	а/д Б.Гаваадамба	Байгалийн болон цацраг, химийн аюулыг үнэлж мэдээлэх алба
16	Б.Ширчин	Мэдээлэл холбооны сүлжээ	а/ч Ж.Нармандах	Мэдээлэл, харилцаа холбооны алба
17	Ж.Энх-Амар	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар	х/ч Ч.Ренчинбаямба	Хүн ам нийгмийн хамгаалалтын алба
18	Т.Чимэддорж	Хас телевиз	а/д С.Пүрэвсүрэн	Сурталчилгааны алба
19	О.Лхагвасүрэн	Онги ус суваг ОНӨААТҮГ	х/ч Б.Батсайхан	Цэвэр бохир усны засварын булэг
20	О.Галбадрах	ЗХ-ний 256 дугаар ангийн захирагч	а/д Г.Ганбаатар	Инженер тэсэлгээний мэргэжлийн анги
21	Н.Мөнхтөр	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Статистикийн хэлтсийн дарга	а/д А.Балжинням	Иргэний бүртгэл мэдээлэл статистикийн мэргэжлийн анги
22	Ц.Доньддорж	Нисэх буудлын дарга	а/х Д.Сандагдорж	Нисэх буудлын аюулгүй байдлын мэргэжлийн анги

Аймгийн Засаг даргын 2019... оны 01.
дугаар сарын 24...ны өдрийн 139 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАД, МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ
ХАНГАХ, ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫГ
ХАРИУЦАН АЖИЛЛАХ ХУВААРЬ

д/д	Нэр	Үндсэн албан тушаал	Хамтран ажиллах албан тушаалтан	Хариуцах алба, мэргэжлийн анги
1	И.Доржсүрэн	Засаг даргын орлогч	а/х С.Уранбаатар	Аймгийн онцгой комисс
2	Ц.Ганболд	Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга	х/ч Ч.Ренчинбаямба	Аймгийн Засаг даргын тамгын газар
3	Д.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга	а/д А.Балжиням	Гал унтраах мэргэжлийн анги
4	М.Дэлгэрсайхан	Цэргийн штабын дарга	а/д С.Пүрэвсүрэн	Хүмүүнлэгийн тусlamжийн мэргэжлийн анги
5	А.Отгонцэцэг	АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга	х/ч Б.Батсайхан	Хуулийн этгээдийн мэргэжлийн анги
6	Д.Нэмэхбаяр	Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга	а/д Б.Ганзориг	Санхүү нөөц хангалтын мэргэжлийн анги
7	Г.Баясгалан	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга	а/х Ж.Ганбаатар	Дулааны шугам сүлжээний засварын мэргэжлийн анги
8	О.Ганбат	Цагдаагийн газрын дарга	а/д Б.Гаваадамба	Хэв журам сахиулах алба
9	Д.Шиваанүрдэв	Эрүүл мэндийн газрын дарга	а/х Н.Намхайнямбуу	Эрүүл мэндийн алба
10	С.Цэдэнбалжир	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга	а/х Ц.Алдаржав	Хүнс, хөдөө аж ахуйн алба
11	С.Дуламсүрэн	Мэргэжлийн хяналтын газрын дарга	а/д Г.Ганбаатар	Мэргэжлийн хяналтын алба
12	Б.Дэмбэрэлсайхан	Эрдэнэт булганы цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компани салбарын дарга	а/х Д.Сандагдорж	Түлш, эрчим хүчний алба